



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2014 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 59

Мандалговь

Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйл, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 3.1.д, 3.2.6.а дугаар заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 13'800'000 /арван гурван сая найман зуун мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, 1'519'620 /нэг сая таван зуун арван есөн мянга зургаан зуун хорь/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй ДУА 39-02 улсын дугаартай, УАЗ-469 маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Автомашиныг худалдах үнийн доод хязгаарыг 3'000'000 /гурван сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Э.Одончимэгт даалгасугай.

ДАРГА

С.БУДЖАВ



0100000107